



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 27 өдөр

Дугаар А/31

Мөрөн сум

Барилга байгууламжийг ашиглалтад
оруулах комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2, 35.1.6, 48 дугаар зүйлийн 48.1, 48.6, Засгийн газрын 2020 оны 246, 2021 оны 212 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөвсгөл аймгийн Мөрөн суманд иргэн Ө.Орхоны үйлчилгээний төвтэй 9 айлын орон сууцны барилгын ажлыг байнгын ашиглалтад оруулах чиг үүрэг бүхий комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:

Б.Энхжаргал (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын
Барилга хот байгуулалтын хэлтсийн дарга)

Гишүүд:

Х.Даваасүрэн Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт,
хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн,
Ерөнхий архитектор)

Д.Мягмарсүрэн (Мэргэжлийн хяналтын газрын Барилга техник хяналтын улсын
байцаагч)

П.Даваа-Очир (Мэргэжлийн хяналтын газрын Барилга техник
хяналтын улсын байцаагч)

Б.Гал-Эрдэнэ (Мэргэжлийн хяналтын газрын Харилцаа холбооны
хяналтын улсын байцаагч)

Л.Бямбасүрэн (Онцгой байдлын газрын Гамшгаас хамгаалах хяналтын
улсын ахлах байцаагч, хошууч)

Ж.Жавзанпагма (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн
хэлтсийн Архивын тасгийн дарга)

Д.Сүхээ (Хөвсгөл ус суваг ХХК-ний Ерөнхий инженер)

Э.Даваахүү (Мөрөн сумын Засаг даргын Тамгийн газрын архитектор, дэд
бүтэц, нийтийн тээвэр хариуцсан ажилтан)

Х.Цанжидмонлом (Хөвсгөл Эрчим хүч ХХК-ний инженер)

П.Цэнгэнжаргал (Хөвсгөл дулааны станц ТӨХК-ийн инженер)
Ц.Оюун-Эрдэнэ (Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын Хөгжлийн
бэрхшээлтэй иргэдийн асуудал хариуцсан мэргэжилтэн)
Д.Нямбат (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын
мэргэжилтэн)
Г.Төмөр (Дулаан-Хаан СӨХ)-ийн дарга

Зураг төслийн байгууллагын төлөөлөл:
Н.Ууганцэцэг (Итгэлт Чандмань ХХК -ийн Захирал)

Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл:
Ч.Баасанжав – (Мөнх Өсөн нэмэх ХХК-ийн Захирал)

Ашиглагч байгууллагын төлөөлөл:
А.Ариунаа – (Эгийн сувд ХХК-ийн Захирал)

Комиссын нарийн бичгийн дарга:
Н.Шинэбаяр (Хөвсгөл аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын
мэргэжилтэн)

2. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах үйл ажиллагааг холбогдох хууль, тогтоомж, Барилга, хот байгуулалтын яамны сайдын зөвлөмж, аймгийн Мэргэжлийн хяналтын газрын зөвлөмж, коронавируст халдвар (Ковид-19)-аас урьдчилан сэргийлж, халдвар хамгааллын дэглэмийг баримтлан зохион байгуулж, комиссын ажлын тайлан, шийдвэрийг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд 2022 оны 02 дугаар сарын 30-ны өдрийн дотор танилцуулахыг Комиссын дарга (Б.Энхжаргал)-д даалгасугай.

3. Барилга байгууламжийг ашиглалтад оруулсантай холбоотой баримт бичгийг бүрдүүлэн аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасаг болон холбогдох байгууллагуудад хүлээлгэн өгөхийг Комиссын нарийн бичгийн дарга (Н.Шинэбаяр) -д үүрэг болгосугай.

4. Комиссын бүрэлдэхүүн чанаргүй барилга, байгууламжийн ажил хүлээн авсан тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгүүлэхийг анхааруулсугай.

5. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН